

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 20/7

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүү, тэтгэврийн зээлийн зохицуулалт болон репо санхүүжилтийн талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдааны эхний хэсэгт макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчинд гарч буй гол өөрчлөлтүүд, КОВИД-19 вирусын тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэлийг Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцууллаа.

Инфляцын төсөөлөл өмнөх 11-р сарын төсөөлөлтэй харьцуулахад ирэх 2 улиралд буурсан болохыг танилцуулав. Үүнд Засгийн газар сайжруулсан түлшний үнийг 12-р сараас ирэх оны 4-р сар хүртэл 75 хувь бууруулах шийдвэр гаргасан нь нөлөөлөв. Харин 2021 оны 2-р хагаст эдийн засгийн өсөлт сэргэж, эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэн, Төв банкны зорилтот түвшний орчимд тогтворжих хүлээлттэй байгааг онцлов.

Эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллийн орчимд байгааг танилцууллаа. Өнгөрсөн 11-р сард шинэ вирусын халдвар дотоодод тархаж бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж, хатуу хөл хорио тогтоосон. Энэ нь уул уурхай, хөдөө аж ахуй, мэдээлэл холбооны салбараас бусад салбаруудыг хүндрүүлэхээр байна. Харин уул уурхайн бүтээгдэхүүний экспорт оны сүүлийн улиралд тогтвортой байж, тээврийн салбарын үйлдвэрлэл буурахгүй гэж үзсэн болохыг дурдав. Ирэх онд гадаад эрэлт сайжрах, Оюу Толгойн зэсийн баяжмал дахь металлын агууламж нэмэгдэх нөлөөгөөр уул уурхайн салбар идэвхжих бол хөл хорио, вирусын тархалтын улмаас уул уурхайн бус салбар сэргэх хугацаа хойшиллоо. Суурь төсөөлөлд ирэх оны 2-р улирлын хагас хүртэл ямар нэгэн байдлаар хорио цээрийн дэглэм үргэлжилэхээр авч үзэхэд жилийн эдийн засгийн өсөлт 6.4 хувьтай байхаар тооцооллоо.

МБГ-ын зүгээс төсвийн гүйцэтгэл, төсөөллийг танилцуулав. Төсвийн нийт орлого энэ оны эхний 11 сард өмнөх оны мөн үеэс 1.65 их наяд төгрөгөөр буурсан бөгөөд аж ахуй нэгжийн ОАТ, НДШ, НӨАТ, АМНАТ-тай холбоотой татварын орлого буурсан нь нөлөөлөв. Харин төсвийн нийт зардал эхний 11

сард өмнөх оны мөн үеэс 30 хувиар нэмэгдсэн ба хөрөнгө оруулалтын зардал энэ онд дутуу гүйцэтгэлтэй гарч болзошгүй байгааг онцлов.

Үргэлжлүүлээд мөнгө, зээлийн өсөлтийг дэлгэрэнгүй танилцуулав. Тодруулбал, М2 мөнгө 2018 оны эхнээс 2020 оны 10 дугаар сарын хооронд 6.8 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Үүнд актив талаас ГЦА 4.9 их наяд төгрөгөөр, зээл 3.6 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол ЗГЦЗ болон бусад цэвэр зүйл бууруулах чиглэлд нөлөөлөв. Харин эх үүсвэр талаас иргэдийн төгрөгийн хадгаламж 3.6 их наяд төгрөг, гадаад валютын хадгаламж 1.7 их наяд төгрөгөөр; хувийн хэвшлийн гадаад валютын хадгаламж 810 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Банкны системийн зээлийн өсөлт сул хэвээр байна. Гадаад, дотоод эдийн засгийн идэвхжил буурч, зах зээлийн эрсдэл өндөр байгаа нь зээлийн эрэлт буурч, зээлийн өсөлт саарахад нөлөөлж байна. Нөгөө талаас банкуудын бизнесийн салбаруудад олгосон хугацаа хэтэрсэн зээлийн дүн нэмэгдэн, банкуудын ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгөд сөргөөр нөлөөлж байгаа нь зээлийн нийлүүлэлтийг бууруулж байна.

Ирэх оноос гадаад эрэлт сэргэх төлөв хэвээр байгааг танилцуулсан бөгөөд өмнөх мөнгөний бодлогын хорооны хурлаас хойш гадаад эрэлтийн төлөв төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Гэвч цаашид КОВИД-19 цар тахлын дараагийн давалгаа үүсч, үүнтэй холбоотойгоор улс орнууд ямар арга хэмжээ авахаас хамаараад гадаад эрэлтийн төлөвд тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг дурьдав.

Эхний 10 сарын байдлаар төлбөрийн тэнцэл 294 сая ам.долларын алдагдалтай байв. Оны сүүлийн 2 сард алтны экспорт нэмэгдэх, хүлээгдэж буй ГШХО, засгийн газрын гадаад санхүүжилт болон хөл хорионы нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил суларч импорт буурах нь гадаад валютын цэвэр урсгалд эерэгээр нөлөөлж, төлбөрийн тэнцэл энэ онд ашигтай гарахаар байна. Мөн төлбөрийн тэнцэл 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирч, ашиг нь нэмэгдэхээр тооцов.

Үргэлжлүүлээд хэрэглээний зээлийн одоо хэрэгжиж буй зохицуулалт, холбогдох саналыг танилцуулав. “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн хүрээнд тэгвэрийн зээлийн зургаан сая төгрөг, түүнээс доош дүнтэй төлбөрийг тэглэсэнтэй холбоотойгоор 2020 оны 2 дугаар сард тэтгэврийн зээлийн үлдэгдэл огцом багассан. Мөн "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо,

зээлийн үйл ажиллагааны тухай /БЭБХЭМХТТЗҮАТ/" хуулийн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлт (29 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг)-өөр зээлдүүлэгч нь зээлдэгчийн тэтгэврийг жилд нэг удаа зургаан сараас дээш хугацаагаар барьцаалахыг хориглох талаар шинэ заалт нэмэгдсэн. Иймээс тэтгэврийн орлого барьцаалсан зээл нь макро зохистой бодлогын хязгаарлалтаас илүү бусад хуулиар зохицуулагдаж байгааг онцлов.

Ийнхүү, Мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах, макро зохистой бодлогын хүрээнд хэрэлээний зээлийн зохицуулалтаас тэтгэврийн зээлийг хасах санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

КОВИД-19 цар тахлын тархалттай холбоотой тодорхой бус байдал өндөр хэвээр, гадаад, дотоод орчны эрсдэл өндөр, эдийн засгийн суурь нөхцөл сайжраагүй байгаа тул эдийн засгийн нөөц боломж, бодлогын орон зайг тодорхой түвшинд хадгалах шаардлагатайг МБХ-ны гишүүд онцолж, бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах шийдвэрт саналд нэгдлээ. Түүнчлэн, тус шийдвэр нь төгрөгийн үнэ цэнийг хадгалж, төгрөгийн ханшийг хамгаалахад дэмжлэг үзүүлэхийг зарим гишүүд дурдав.

Макро зохистой бодлогын хүрээнд гаргасан саналыг гишүүд 100 хувийн саналаар дэмжлээ. Тэтгэврийн орлого барьцаалсан зээл нь макро зохистой бодлогын хязгаарлалтаас илүү бусад хуулиар зохицуулагдаж эхэлсэн бөгөөд банкнаас шинээр олгосон тэтгэврийн зээлийн дундаж хугацаа харьцангуй буурсан тул өр, орлогын харьцаа тооцох макро зохистой бодлогын зохицуулалтаас тэтгэврийн зээлийг хасах нь зүйтэй гэсэн нэгдсэн байр суурийг гишүүд илэрхийллээ.

Хуралдааны дараагийн хэсэгт Төв банкны мөнгөний бодлогын хэрэгсэл болох репо санхүүжилтийн хэмжээг тогтоохтой холбоотой саналыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газраас танилцуулж, хэлэлцүүлэв.

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 9 дүгээр сарын ээлжит хурлаар урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг 230 хүртэлх тэрбум төгрөгөөр тогтоож, Монголбанкнаас холбогдох журам, ерөнхий гэрээг байгуулан хоёр удаагийн арилжаагаар тус санхүүжилтийг банкуудад олгоод байна. Ингэхдээ хөл хорио тогтоосонтой холбоотойгоор энэ оны 4 дүгээр улиралд банкуудад 100 хүртэл хувиар дахин санхүүжүүлэх боломжийг олгон цаашид нөхцөл байдал хэвийн үргэлжлэх үед 70 хувийг шинэ зээлд, 30 хувийг дахин санхүүжүүлэхэд

зориулах ерөнхий шаардлагыг Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар баталсныг дурдлаа.

Ирэх оны 1 дүгээр улиралд 250 хүртэлх тэрбум төгрөгийн эх үүсвэрийг урт хугацаат санхүүжилтийн хэрэгслээр гаргаснаар жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус салбарын зээлийн өсөлтийг өмнөх жилүүдийн дунджийн орчимд хадгалах боломжтойг танилцууллаа. Ийнхүү хөл хорионы дэглэм үргэлжилж, эдийн засаг, санхүүгийн салбарт тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нөхцөл байдлыг харгалзан ирэх оны 1 дүгээр улирлын урт хугацаат репо арилжааны дээд хэмжээг 250 тэрбум төгрөгөөр тогтоож, эх үүсвэрийг 100 хүртэл хувиар дахин санхүүжүүлэх зөвшөөрлийг банкуудад олгох санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцэв.

МБХ-ны гишүүдийн хувьд зээлийн тасалдал үүсэх эрсдэл өндөр байгаа одоогийн нөхцөлд төв банкнаас эх үүсвэрийн нийлүүлэлтийг дэмжих зайлшгүй шаардлага үүсч байгаа тул тус саналыг дэмжихээ илэрхийллээ. Харин аливаа төрлийн гажуудал үүсгэхгүй байх үүднээс зээлийг шалгаж авах үйл явц, гэрээ, үнэт цаасжуулалт хийх зэрэгт сайн анхаарч, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад хяналт тавьж ажиллахыг сануулав. Түүнчлэн, олон нийтэд тайлбарлах, зорилтот бүлэг буюу жижиг, дунд бизнес эрхлэгчдэд мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах шаардлагатайг дурдлаа.

Улмаар МБХ-ны гишүүд жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 1 дүгээр улиралд 250 хүртэлх тэрбум төгрөгийн санхүүжилт олгох саналыг 100 хувь дэмжлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлаар:

1. Бодлогын хүүг хэвээр хадгалах;
2. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 1 дүгээр улиралд 250 хүртэлх тэрбум төгрөгийг олгох шийдвэрийг гаргалаа.